



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 17/39

Сүхбаатар сум

### Тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах тухай

Монгол Улсын аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.2, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандал сумын Түнхэл тосгоны “Сансар трейд “ХХК-ий “Түнхэл” ахмадын сувилалд шинээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Хүдэр, Ерөө, Хушаат, Орхонтуул сумд, Мандал сумын Түнхэл тосгоны эмийн эргэлтийн сангууд, Зүүнбүрэн сумын “Бүрэн тун”, Мандал сумын “Энхийн тун” эмийн сангуудын тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

3. Баруунбүрэн сум, Сайхан сумын Номгон тосгоны эмийн эргэлтийн сангууд, Сүхбаатар сумын “Буянт рашаан-2”, “Буянт рашаан-4”, Бугант тосгоны “Өлгий”, Ерөө сумын эмийн сан, Сүхбаатар сумын “Гэрэл” лаборатори, “Мөнгөн зүү”, “Итгэлт-Ачтан” уламжлалтын эмнэлэгүүд, Мандал сумын “Ачлал” шүдний эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 1 жил 6 сарын хугацаатайгаар тус тус сунгасугай.

4. Орхонтуул сумын Рашаант тосгоны “Энхийн илч” эмийн сан, Сүхбаатар сумын “Сэлэнгэ-Монос” эм ханган нийлүүлэх байгууллага, Мандал сумын “Инээмсэглэл” шүдний эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

5. Тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/43

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах,  
тусгай зөвшөөрлийг цуцлах тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.2, Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.11.1 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мандал сумын “Бум хараа” сувиллын тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жил 5 сар, “Нямзул” дотор, эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жил, Мандал суман дахь Нэгдсэн эмнэлгийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

2. Сүхбаатар сумын “Эм хангамж”-ийн төв эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаатайгаар сунгасугай.

3. Сүхбаатар сумын “Эм хангамж”-ийн төв эмийн сан, Мандал сумын Түнхэл тосгоны эргэлтийн эмийн сангийн мансууруулах эмээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жилээр тус тус сунгасугай.

4. Сайхан сумын “Өгөөж найрамдал” ХХК-ий “Гавшгай” эмийн сангийн мансууруулах эмээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг цуцалсугай.

5. Тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Д.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БҮРЭНБАТ